



ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ
СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН
ТУШААЛ

2024 оны 10 сарын 25 өдөр

Дугаар А/184

Улаанбаатар хот

“Сэтгэцийн урьдчилан сэргийлэх үзлэг,
оношилгоо, шинжилгээ хийх” журам шинэчлэн
батлах тухай

Монгол улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх заалт, Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Сэтгэцийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоо, шинжилгээ хийх” журмыг нэгдүгээр, “Сэтгэцийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоо, шинжилгээний төрөл, төлбөрийн хэмжээ”-г хоёрдугаар, “Сэтгэцийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийн маягт”-ыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Энэхүү тушаалыг хэрэгжүүлэн ажиллахыг Эмнэлзүй хариуцсан дэд захирал (Н.Оюунчимэг)-д, өдөр тутмын үйл ажиллагаагаар хангаж ажиллахыг амбулаторийн эрхлэгч (Т.Ганцэцэг)-д, орлого, зарцуулалтыг хариуцан ажиллахыг санхүү бүртгэлийн алба (Б.Гэрэлээ)-д тус тус даалгасугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Үйл ажиллагаа хариуцсан дэд захирал (О.Баатаржав)-д даалгасугай.

4.Энэхүү тушаал гарсантай холбоотой Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн захирлын 2023 оны 01 дүгээр сарын 20-ний өдрийн А/12 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Г.АНХБОЛД



132431289

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн
захирлын 2024 оны 10-р сарын 25-ны өдрийн
01124 дугаар тушаалын 1 хавсралт

СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЗЛЭГ, ОНОШИЛГОО, ШИНЖИЛГЭЭ ХИЙХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Энэхүү журмын зорилго нь сэтгэцийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоо, шинжилгээ (цаашид “Урьдчилан сэргийлэх үзлэг” гэх) хийхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.
- 1.2 Сэтгэцийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийг хүчин төгөлдөр мөрдөж байгаа Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан тушаалын дагуу үйлчилгээний жишиг төлбөрийг баримтлан гүйцэтгэнэ.

Хоёр. Сэтгэцийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийн зохион байгуулалт

- 2.1 Урьдчилан сэргийлэх үзлэгийг байгууллагын үйл ажиллагааг доголдуулахгүйгээр төвийн Захирал болон Эмнэлзүй хариуцсан дэд захирал нэгдсэн удирдлагаар хангаж ажиллана.
- 2.2 Шаардлагатай тохиолдолд үзлэг хийх эрх бүхий албан тушаалтныг төвийн Захирал болон Эмнэлзүй хариуцсан дэд захирал томилно.
- 2.3 Урьдчилан сэргийлэх үзлэгийг амбулаторийн нөхцөлд болон амбулаториос гадуур хийх ба амбулаториос гадуур хийх тохиолдолд төвийн Захирал болон Эмнэлзүй хариуцсан дэд захирлын баталсан удирдамжийн дагуу хийнэ.
- 2.4 Сэтгэцийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийн “Багц 1” - ын үзлэгийг сэтгэцийн эмч, “Багц 2” - ын үзлэгийг амбулаторийн эрхлэгч ахалж, хоёр сэтгэцийн эмч, “Багц 3”, “Багц 4” – ын үзлэгийг Хүүхэд, өсвөр үеийн сэтгэцийн эмч нар хийж гүйцэтгэнэ.
- 2.5 Амбулаторийн кабинетаар үзүүлэх тохиолдолд эрхлэгч зохицуулалт хийж ажиллана.
- 2.6 Урьдчилан сэргийлэх үзлэгээр эмгэг сэтгэл судлалын шинжилгээ хийлгэх шаардлага үүсвэл тусдаа цаг авч шинжилгээ хийлгэх ба тарифын дагуу төлбөр нэмж төлнө.
- 2.7 Үйлчлүүлэгч өөрөө хүсвэл нэмэлтээр сорил, шинжилгээ хийлгэж болно.
- 2.8 Шаардлагатай тохиолдол (сонгуульд нэр дэвшигч, шүүгч, нисгэгч зэрэг)-д төвд хэвтэж эмчлүүлсэн, тусламж, үйлчилгээ авдаг эсэх талаар лавлагааг гаргуулж үзлэгийг хийнэ.
- 2.9 Сэтгэцийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийн “Багц 1”-ын үзлэг, оношилгоо, шинжилгээний хариу бүхий дүгнэлтийг тэр даруйд нь, “Багц 2”, “Багц 3”, “Багц 4” - ын дүгнэлтийг ажлын 2-4 хоногт багтаан гаргах ба тухайн байгууллагад албан бичгээр хүргүүлнэ.
- 2.10 Сэтгэцийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээний дүн өөрчлөлттэй гарсан үйлчлүүлэгчийг эмчилж, хянах арга хэмжээг авна.

- 2.11 Албан байгууллагаас хүсэлттэй ирсэн тохиолдолд үзлэг шинжилгээний хариу бүхий дүгнэлтийг албан бичгээр (шаардлагатай тохиолдолд үйлчлүүлэгч өөрт нь өгөхгүйгээр) заавал хүргүүлнэ.
- 2.12 Төв нь сэтгэцийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийн мэдээллийг ил тод, ойлгомжтой хэлбэрээр ханын самбар болон цахим хуудсанд байршуулан үйлчлүүлэгчийг үнэн зөв мэдээллээр хангана.
- 2.13 Урьдчилан сэргийлэх үзлэгийг байгууллага хоорондын гэрээгээр гүйцэтгэж болно.

Гурав. Сэтгэцийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг хийхэд баримтлах зүйлс

- 3.1 Үйлчлүүлэгчийн сонгосон багцын тусламж, үйлчилгээг холбогдох стандарт, удирдамж, арга, аргачлалын дагуу одоогийн сэтгэцийн байдлыг тогтоох үзлэгийг үнэн зөв, бүрэн хийнэ.
- 3.2 Сэтгэцийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийн “Багц 1”-ын хариу бүхий дүгнэлтийг үзлэг хийсэн сэтгэцийн эмч, “Багц 2”, “Багц 3”, “Багц 4” - ын дүгнэлтийг үзлэг хийсэн сэтгэцийн эмч, амбулаторийн эрхлэгч эмч, зарим тохиолдолд эмнэлгийн удирдлага, эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурж албаны тэмдгээр баталгаажуулна.
- 3.3 Сэтгэцийн эрүүл мэндийн үзлэгийн маягтыг батлагдсан загварын дагуу хэвлүүлж, ашиглана.

Дөрөв. Үйлчлүүлэгчдийн эрх, үүрэг

- 4.1 Сэтгэцийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдахыг хүссэн үйлчлүүлэгч болон албан байгууллага нь сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний багцаас сайтар танилцан сонгож, холбогдох төлбөрийг бүрэн төлнө.
- 4.2 Урьдчилан сэргийлэх үзлэгийн үйл ажиллагаа, тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийн талаарх санал, хүсэлт, гомдлыг гаргаж болно.


Тав. Хориглох зүйл

- 5.1 Энэхүү тушаалын хавсралтад заасан төлбөрийн жишиг хэмжээнээс хэтэрсэн төлбөр нэхэмжлэхгүй байх
- 5.2 Үзлэгийг ажлын бус өдөр болон тохиролцож үзлэг хийх
- 5.3 Байгууллагын данснаас өөр дансанд болон бэлнээр үйлчилгээний төлбөр шилжүүлэхийг шаардах

Зургаа. Хариуцлага

- 6.1 Энэ журмыг зөрчсөн тохиолдолд буруутай байгууллага, албан тушаалтан, үйлчлүүлэгч хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн
захирлын 2024 оны 10-р сарын 25-ны өдрийн
А/184 дугаар тушаалын II хавсралт



**СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЗЛЭГ,
ОНОШИЛГОО, ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨРӨЛ, ТӨЛБӨРИЙН ХЭМЖЭЭ**

Багц 1

| № | Шинжилгээний нэр | Төлбөрийн хэмжээ |
|---|--------------------------------------------------------------------|------------------|
| 1 | Сэтгэцийн эмчийн үзлэг | 45.000 |
| 2 | Сэтгэлзүйн оношилгоо (нойргүйдэл, архи, тамхины хамаарал илрүүлэх) | |

Багц 2

| № | Шинжилгээний нэр | Төлбөрийн хэмжээ |
|---|---------------------------------------------------------------------------------------------------|------------------|
| 1 | Сэтгэцийн эмчийн үзлэг | 65.000 |
| 2 | Сэтгэлзүйн оношилгоо (нойргүйдэл, сэтгэл түгшилт, сэтгэл гутрал, архи, тамхины хамаарал илрүүлэх) | |
| 3 | Сэтгэц идэвхт бодис (10 нэр төрөл) - ыг шээсэнд илрүүлэх | |


Багц 3

| № | Шинжилгээний нэр | Төлбөрийн хэмжээ |
|---|--------------------------------------------|------------------|
| 1 | Хүүхдийн сэтгэцийн эмчийн үзлэг (5-10 нас) | 40.000 |
| 2 | Хүүхдийн оюуны түвшин тогтоох шинжилгээ | |

Багц 4

| № | Шинжилгээний нэр | Төлбөрийн хэмжээ |
|---|-----------------------------------------------------------|------------------|
| 1 | Хүүхэд, өсвөр үеийн сэтгэцийн эмчийн үзлэг (11-17 нас) | 50.000 |
| 2 | Сэтгэц идэвхит бодис (10 нэр төрөл) - ыг шээсэнд илрүүлэх | |

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн
захирлын 2024 оны 10-р сарын 25-ны өдрийн
№/184 дугаар тушаалын Д хавсралт



СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

**СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН УРЬДЧИЛАН
СЭРГИЙЛЭХ ҮЗЛЭГИЙН МАЯГТ**

| | | | | |
|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------|-------|
| Үйлчлүүлэгчийн овог: | Үйлчлүүлэгчийн нэр: | Регистрийн дугаар: | Нас: | Хүйс: |
| Тогтмол хаяг: | Ажиллаж буй байгууллагын нэр: | Иргэний харьяалал: <input type="checkbox"/> Монгол улсын иргэн <input type="checkbox"/> Гадаад улсын иргэн (улс бичих) | | |
| Сэтгэцийн эмчийн үзлэг, дүгнэлт: | | | | |
| Цаашид өгөх зөвлөгөө: Тийм, Үгүй (зурах) | | | | |
| Амбулаторийн эрхлэгч: /...../ тамга гарын үсэг нэр Үзлэг хийсэн эмч: /...../ гарын үсэг нэр Үзлэг хийсэн: 20 ... оны ... сарын ... өдөр | | | | |